



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нийцлийн аудитын тайлан

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт



**УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ГЭРЭЭГЭЭР АЖИЛ,
ҮЙЛЧИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭСЭН ХУУЛИЙН ЭТГЭЭДҮҮД ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ
ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.**

2018 ОН

АГУУЛГА

<p><u>Тайланг бэлтгэсэн:</u></p> <p>Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар</p> <p>Дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа</p> <p>Аудитын менежер Г.Наранбаяр</p> <p>Аудитор Б.Анхтуяа</p> <p>2018 оны 10-11 дүгээр сар</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7054-3151 дугаарын утас, 7054-3179 дугаарын факсаар харилцана уу.</p> <p>ХАЯГ: Аймгийн Засаг даргын тамгын газрын байр, 2 давхар, 217 тоот</p>	<p>Товчилсон үгийн тайлбар4</p> <p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....5</p> <p>Бүлэг 1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын цэс бүрэн нээгдсэн боловч мэдээллийг бүрэн байршуулаагүй байна.</p> <p>1.1 Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд хуульд заасан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хугацаанд нь бүрэн мэдээлээгүй байна.</p> <p>1.2 Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчид шилэн дансны мэдээллийг байгууллагын мэдээллийн самбарт бүрэн мэдээлэхгүй байна.</p> <p>Бүлэг 2. Хуулийн 3.1.4-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хамрагдаагүй байна.</p> <p>2.1. Шилэн дансны тухай хуулийн 3.1.3-т хамаарах “Шивээ Овоо” ХК нь нийт мэдээллийн 17.5% буюу 11 мэдээлэл огт байршуулаагүй, 71.2%-ийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.</p> <p>2.2. Шилэн дансны тухай хуулийн 3.1.4-т хамаарах улсын төсвийн хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр нийт 2,631.2 сая төгрөгийн ажил гүйцэтгэсэн 43 хуулийн этгээд огт мэдээлэл байршуулаагүй байна.</p> <p>2.3. Шилэн дансны тухай хуулийн 3.1.5-д хамаарах 4 хувийн цэцэрлэгээс 1 нь уг хуулийн 6 дугаар зүйлийн 6.9-д заасан мэдээллийг бүрэн байршуулаагүй байна.</p> <p>Бүлэг 3. Шилэн дансны тухай хуульд заасан хөндлөнгийн хяналтыг сумдын ИТХ, ИНХ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.</p> <p>3.1. Шивээговь, Баянтал сумын ИТХ болон багийн ИНХ нь хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.</p> <p>3.2. Хуулийн 3.1.4-д заасан байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд төсвийн ерөнхийлөн захирагчид хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.</p>
--	---

	<p>3.3. Шилэн дансны нэгдсэн цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан мэдээлэл иргэд, олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар хүрэхгүй байна.</p> <p>3.4. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг Шивээговь, Баянтал сумдын ИТХ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.</p> <p>Дүгнэлт.....</p> <p>Зөвлөмж.....</p>
--	--

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АИТХ	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал
БХС	Байгаль хамгаалан сан
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
УИХ	Улсын Их Хурал
МХС	Мал хамгаалах сан
НАГ	Нийцлийн Аудитын Газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СХС	Сум хөгжүүлэх сан
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төсвийн байнгын хорооны 2017 оны “Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдэв батлах тухай” 06 дугаар тогтоол, Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжийн дагуу Монгол Улсын Ерөнхий аудиторт Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газраас 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөө, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

2. Аудитын зорилт:

Аймгийн төрийн болон улс, орон нутгийн өмчит байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулан дүнг ҮАГ-ын НАГ-т болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгуулах, давтан гаргуулахгүй байхад аудитын зорилго чиглэгдлээ.

3. Аудитын хамарсан хүрээ:

Аудитад Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан хуулийн этгээд, байгууллага, албан тушаалтны 2017 оны 10 дугаар сарын 01-нээс 2018 оны 09 дүгээр сарын 30-ныг хүртэлх үйл ажиллагааг хамруулав.

4. Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөр, АДБОУС 100-400, 4200, Төрийн хяналт шалгалтын стандартыг баримтлан аудитын арга зүйн дагуу Шилэн дансны тухай хуулийн 3, 8 дугаар зүйлд заасан байгууллага, аж ахуй нэгжийн нэгдсэн болон өөрийн цахим хуудас, мэдээллийн самбарт байрлуулсан мэдээллийг, төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналтын хэрэгжилтийн тайлан, дансны хуулгын дүн, анхан шатны баримттай тулгах, санхүүгийн мэдээллийн самбарыг бодит байдал дээр нь очиж үзэх зэрэг аудитын горимуудыг ашиглалаа.

5. Аудитын багийн бүрэлдэхүүн:

Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, аудитын менежер Г.Наранбаяр, аудитор Б.Анхтуяа нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

6. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал, түүнд хийсэн тайлбар, хавсралт гэсэн бүтцээр үндсэн зорилтын дагуу бичигдсэн.

1. Үндсэн мэдээлэл:

Аймгийн хэмжээнд улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа, ил тод, нээлттэй ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх зорилго бүхий Шилэн дансны тухай хууль 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн бөгөөд жил бүр Нийцлийн аудит хийгдэж ирсэн байна.

Аудитын батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан аудитын зорилт, дэд зорилтуудын дагуу Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2, 3.1.3, 3.1.4, 3.1.5-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдаж байгаа, тэдгээр нь хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг бүрэн мэдээлж байгаа, 8 дугаар зүйлийн 8.1, 8.2-т заасан байгууллага, албан тушаалтан хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж байгаа эсэхийг аудитаар онцгойлон анхаарч үзлээ.

Аудитад Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан улсын төсвийн 23, орон нутгийн 51, нийт 74 төрийн болон орон нутгийн төсөвт албан газар, төсөл, хөтөлбөр, сан, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг хамруулав.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу аймгийн ИТХ болон Сүмбэр, Шивээговь сумдын ИТХ нь шилэн дансны үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан талаарх ажлын тайлан, мэдээлэл ирүүлсэн ба Баянтал сумаас ирүүлээгүй байна.

Бүлэг 1

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын цэс бүрэн нээгдсэн боловч мэдээллийг бүрэн байршуулаагүй байна.

1.1. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд хуульд заасан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хугацаанд нь бүрэн мэдээлээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийж буй Нийцлийн аудитаар төрийн болон орон нутгийн өмчит нийт 74 байгууллага, сан, төсөл хөтөлбөрүүдийг хамруулан шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цэс бүрэн нээгдсэн байна.

Сүмбэр сумын ИТХ-ын тогтоолоор тус сумын Байгаль хамгаалах сан, Мал хамгаалах сангийн дансдыг хаан ОНХС дансанд нэгтгэсэн бөгөөд харин Шивээговь, Баянтал сум нь Байгаль хамгаалах сан, Мал хамгаалах сангийн дансдыг хаалгаагүй, гүйлгээ гарахгүй байгаа бөгөөд мэдээллүүдийг хамааралгүй буюу гүйлгээ гараагүй гэж мэдээлсэн байна.

Иймд уг дансдыг Сангийн яам болон аймгийн СТСХ-ээс хүргүүлсэн чиглэлийн дагуу ОНХС-д нэгтгэн Шилэн дансны нэгдсэн цахим хуудсан дахь цэсийг хаалгах тухай зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсан дахь 8 байгууллагын нэр улсын бүртгэлийн гэрчилгээнд бүртгэгдсэн албан ёсны нэрээс зөрүүтэй байна.

Нэр зөрүүтэй байгууллагуудыг хүснэгтээр харуулбал:

№	Байгууллагын албан ёсны нэр	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд дахь нэр
1	Говьсүмбэр аймаг дахь Цагдаагийн хэлтэс	Говьсүмбэр аймаг дахь Цагдаагийн газар
2	ШШГА - 425 дугаар нээлттэй хорих анги	Хорих 425-р анги
3	Боловсрол, соёл, урлагийн газар	Говьсүмбэр аймаг Боловсрол соёлын газар
4	Аймгийн Нэгдсэн эмнэлэг	Говьсүмбэр аймаг аймгийн Нэгдсэн эмнэлэг
5	Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	Говьсүмбэр аймаг Хүүхэд, гэр бүл хөгжил хэлтэс
6	Цөм сүргийн үржлийн төв	Говьсүмбэр аймаг Цөм сүрэг үржлийн төв
7	Сүмбэр сумын 5 дугаар сургууль	Сүмбэр сумын 5 дүгээр сургууль
8	Шивээговь сумын Эрүүл мэндийн төв	Говьсүмбэр Шивээговь сумын Хүн эмнэлэг

Хүснэгтээс харахад дээрх байгууллагууд нь байгууллагын албан ёсны нэр өөрчлөгдсөн тухай бүрт байгууллагын нэрийг солиулаагүйтэй холбоотой байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан аймгийн хэмжээний нийт 74 байгууллагын мэдээллийг графикаар харуулбал:

Мэдээлэл байршуулсан байдлыг байгууллагын тоонд харьцуулан хувиар харуулбал



Графикаас харахад: дээрх 16 үзүүлэлтээс 4 үзүүлэлтийн хэрэгжилт 91.4-95.5%-тай байгаа бөгөөд дараах байгууллагууд мэдээлэл дутуу байршуулсантай холбоотой байна. Үүнд:

1. Тухайн жилийн төсвийг мэдээлвэл зохих 67 байгууллагаас 64 байгууллага буюу 95.5% нь мэдээлсэн бол Баянтал сумын 4-р сургууль, 4-р цэцэрлэг, Соёлын төв гэсэн 3 байгууллага мэдээлээгүй,
2. Эхний хагас жилийн санхүүгийн тайланг мэдээлвэл зохих 70 байгууллагаас 64 байгууллага буюу 91.4% нь мэдээлсэн бол Баянтал сумын ЗДТГ, Сум хөгжүүлэх сан, 4-р сургууль, 4-р цэцэрлэг, Соёлын төв, “Талын илч” ОНӨҮГ гэсэн 6 байгууллага мэдээлээгүй,
3. Жилийн эцсийн санхүүгийн тайланг мэдээлвэл зохих 70 байгууллагаас 66 байгууллага буюу 94.2% нь мэдээлсэн бол 1-р цэцэрлэг, Баянтал сумын ЗДТГ, ИТХ, Эрүүл мэндийн төв гэсэн 4 байгууллага мэдээлээгүй,

4. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор мэдээлвэл зохих 70 байгууллагаас 65 байгууллага буюу 92.9% нь мэдээлсэн бол Баянтал сумын ЗДТГ, ИТХ, 4-р цэцэрлэг, соёлын төв, Эрүүл мэндийн төв тус тус мэдээлээгүй байна.

Эдгээр зөрчлүүд нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.1.1, 6.1.4, 6.1.5 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Дээрх зөрчлүүд нь байгууллагуудын шилэн данс хариуцсан ажилтнууд шилэн дансанд холбогдох мэдээллийг оруулахдаа нэгдсэн цахим хуудас дахь маягтыг бүрэн бөглөх шаардлагатай боловч байгууллагын үйл ажиллагаатай холбогдолгүй гэсэн хайхрамжгүй үйлдлээс мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулаагүйтэй холбоотой байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээллийг холбогдох тайлан, баримт материал, нотлох зүйлстэй тулган баталгаажуулахад дараах зөрчил дутагдлууд илэрлээ. Үүнд:

- Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-д зааснаар таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээллийг мэдээлвэл зохих 74 байгууллага нийт 4,773.4 сая төгрөгийн 646 гүйлгээг мэдээлсэн боловч 8.5 сая төгрөгийн 1 гүйлгээг дутуу мэдээлсэн байна.
- Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д зааснаар цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг мэдээлвэл зохих 74 байгууллага 21,975.3 сая төгрөгийн 2415 гүйлгээг мэдээлсэн бол 14 байгууллага 622.4 сая төгрөгийн 91 гүйлгээг мэдээлээгүй байна.
- Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д зааснаар таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээг мэдээлвэл зохих 74 байгууллагаас 94.5% буюу 70 байгууллага нийт 20,644.3 сая төгрөгийн 730 гүйлгээг мэдээлсэн ба Нэгдсэн эмнэлэг, Шивээговь сумын Сум хөгжүүлэх сан огт мэдээлээгүй, Сүмбэр сумын Сум хөгжүүлэх сан, “Илчлэг шивээ” ОНӨҮГ 71.3 сая төгрөгийн гүйлгээг дутуу мэдээлсэн байна.
- Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.6-д заасан Худалдан авалтын аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн болон 6.4.7-д заасан байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт зэргийг мэдээлвэл зохих байгууллагууд бүрэн мэдээлсэн байна.
- Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасан Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч хөрөнгө, мөнгө

зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг мэдээлвэл зохих 36 байгууллагаас 18 байгууллага буюу 50.0% нь 857.5 сая төгрөгийн 437 шийдвэрийг мэдээлсэн бол 18 байгууллага 340.5 сая төгрөгийн 341 шийдвэрийг огт мэдээлээгүй байна.

- Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.9-д хууль тогтоомжид заасан бусад мэдээллийг мэдээлвэл зохих байгууллагууд 100.0% мэдээлсэн байна.
- Шилэн дансны дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.4-т заасан мэдээллүүдийг хэрхэн мэдээлэх талаар зөрүүтэй ойлголттой байгаагаас цалингийн зардлаас бусад таван сая төгрөгнөөс дээш орлого, зарлагын мөнгөн гүйлгээ хэсэгт зарим байгууллага санхүүжилтийн орлогыг мэдээлсэн бол зарим нь огт мэдээлээгүй байна.

Эдгээр нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8 дахь заалтуудыг зөрчсөн бөгөөд зарим байгууллагууд мэдээллийг дутуу байршуулснаас нийт 1,156.0 сая төгрөгийн ажил гүйлгээг огт мэдээлээгүй байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бие даасан цэс нээсэн байгууллагын мэдээлэл оруулсан байдлыг өмнөх онтой харьцуулан диаграмаар харуулбал:



Диаграмаас харахад: Нийт 74 цэс нээлгэснээс 64.0% буюу 47 байгууллага мэдээллээ бүрэн оруулж, 36.0% хувь буюу 27 байгууллага мэдээллийг алдаатай буюу дутуу байршуулсан бөгөөд мэдээлэл дутуу байршуулсан байгууллагын тоо өмнөх оноос 32.0%-иар буурсан байна.

Мэдээллээ дутуу байршуулсан байгууллагуудын судалгааг хүснэгтээр харуулбал:


/сая төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ	Хөрөнгө зарцуулах тушаал шийдвэр	5 сая төгрөгөөс дээш зарлагын гүйлгээ	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл
1	Нэгдсэн эмнэлэг	68.0			
2	Сүмбэр СХС	43.1	114.8		
3	Шивээговь СХС	45.3			
4	Илчлэг шивээ ОНӨҮГ	28.2	1.2		
5	1-р сургууль		63.1		
6	2-р сургууль		23.2		
7	5-р сургууль		30.4	66.4	
8	1-р цэцэрлэг		12.9	22.3	
9	2-р цэцэрлэг		8.6	5.4	
10	5-р цэцэрлэг		4.1	1.8	
11	Шивээговь ИТХ		2.0	5.0	
12	Шивээговь ЗДТГ		17.2		
13	Шивээговь ЭМТ		9.9		
14	Баянтал ИТХ		1.3	5.0	
15	Баянтал ЗДТГ		13.3	11.0	
16	Баянтал ОНХС		34.2		
17	4-р сургууль		0.1	40.4	
18	4-р цэцэрлэг		1.5		
20	Баянтал ЭМТ		1.4	28.1	
21	Талын Илч ОНӨҮГ		1.3		
22	3-р сургууль			49.0	
23	3-р цэцэрлэг			39.0	
24	Сүмбэр ЗДТГ				8.5
25	ГХБХБГ			31.3	
26	АИТХ			288.2	
27	Усны сав газар			29.5	
	Нийт	184.6	340.5	622.4	8.5
			1,156.0		

Хүснэгтээс харахад: дутуу байршуулсан мэдээллийн 16.0%-ийг 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ, 29.5%-ийг хөрөнгө зарцуулах тушаал шийдвэр, 53.8%-ийг 5 сая төгрөгөөс дээш зарлагын гүйлгээ, 0.7%-ийг таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл эзэлж байна.

Орон нутгийн зарим байгууллага, хуулийн этгээд хуульд заасан хугацаанд нь мэдээллээ байршуулаагүйгээс нийт 1,205 мэдээлэл хугацаа хоцорсон төлөвтэй байна.

Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан байдлыг өмнөх онтой харьцуулан диаграмаар харуулбал:



Диаграмаас харахад: Хугацаа хоцорсон зөрчил өмнөх оноос 20%-иар буурсан үзүүлэлттэй байгаа ба нийт байршуулсан мэдээллийг 13.0% нь хугацаа хоцорсон бөгөөд хугацаа хоцроож мэдээлсэн байгууллагуудын хувьд 1-70 удаагийн мэдээлэл хоцорсон төлөвтэй байна.

Байгууллагууд Шилэн дансны хуулийн дагуу Шилэн дансны цахим хуудсанд холбогдох мэдээллийг байршуулахдаа дараах алдаа, зөрчлийг гаргасан байна. Үүнд:

- Хөрөнгө зарцуулах болон тэтгэмж олгосон тушаал, шийдвэрийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн мэдээлээгүй, зарим байгууллага эрх бүхий албан тушаалтны шийдвэрийн мэдээлэл оруулсан боловч уг шийдвэрийг файлаар байршуулаагүй,
- Таван сая төгрөгөөс дээш цалингийн зардлаас бусад орлого, зарлагын гүйлгээг тухай бүр мэдээлээгүй
- Зарим байгууллагууд санхүүгийн тайланг мэдээлсэн төлөвтэй харагдаж байгаа боловч холбогдох файлыг хавсаргаагүй, хоосон цэсийг баталгаажуулсан

Эдгээр нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэснийг зөрчжээ.

Иймд зөрчил гаргасан дээрх байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудад хуулийн дагуу хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

1.2 Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчид шилэн дансны мэдээллийг байгууллагын мэдээллийн самбарт бүрэн мэдээлэхгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7, 5.8-д шилэн дансны мэдээллийг цахим хуудастай эсэхээс үл хамааран мэдээллийн самбарт байрлуулахаар заасан байна.

Аудитын явцад шилэн дансны цахим хуудсан бүртгэлтэй 74 байгууллагаас 45.9% буюу 34 байгууллагыг түүвэрт хамруулан шилэн дансны мэдээллийг мэдээллийн самбарт хуульд заасан шаардлагын дагуу бүрэн мэдээлж байгаа эсэхийг тулган шалгалаа. Шалгалтаар илэрсэн нийтлэг зөрчлүүдийг дурьдвал:

1. Ихэнх байгууллагууд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах тушаал шийдвэрийг мэдээлдэггүй
2. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгнөөс дээш орлого, зарлагын мөнгөн гүйлгээг мэдээлдэггүй
3. Сүмбэр сумын ИТХ нь мэдээллийн самбар байхгүй
4. “Илчлэг-Шивээ” ОНӨҮГ нь зөвхөн сар бүрийн зардлын гүйцэтгэлийг мэдээлсэн байна.

Мэдээллийн ил, тод байдал мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу Сүмбэр сумын ИТХ-аас бусад байгууллагууд мэдээлэл байршуулах боломж нөхцлийг ханган мэдээллийн самбарыг хийлгэж байршуулсан боловч мэдээллийг бүрэн мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8, Мэдээллийн ил, тод байдал мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд дээрх хуулиудын дагуу мэдээллийн самбарт мэдээллүүдийг бүрэн байршуулж байх, хуульд заасан мэдээллийг мэдээллийн самбарт бүрэн мэдээлж буй эсэхэд тухай бүр хяналт тавьж, харъяа байгууллагуудтай хамтран ажиллах талаар аймгийн СХАА, төсвийн захирагч нарт зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4, 3.1.5-д заасан байгууллагууд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг бүрэн мэдээлсэн эсэх

Бүлэг 2

Хуулийн 3.1.4-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хамрагдаагүй байна.

2.1. Шилэн дансны тухай хуулийн 3.1.3-т хамаарах “Шивээ Овоо” ХК нь нийт мэдээллийн 17.5% буюу 11 мэдээлэл огт байршуулаагүй, 71.2%-ийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

“Шивээ-Овоо” ХК нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, Худалдан авах ажиллагааны тайлан, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр,

хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг мэдээлэхээр цэс нээгдсэн байна.

2017 оны 10 сараас 2018 оны 09 дүгээр сарыг дуустал нийт 63 мэдээлэл оруулахаас 52 мэдээлэл оруулж, 11 мэдээллийг оруулаагүй байна. Тухайлбал, 2017 онд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр, концессийн мэдээлэл, худалдан авах ажиллагааны тайлан, 2018 оны хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл гэсэн 11 мэдээллийг байршуулаагүй байна.

Нийт байршуулсан 52 мэдээллээс 37 мэдээлэл буюу 71.2% нь хугацаа хоцорсон төлөвтэй байна.

Эдгээр нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8, 6.8.1, 6.8.2, 6.8.3 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

“Шивээ-Овоо” ХК-д холбогдох мэдээллийг хугацаанд нь оруулж байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

2.2. Шилэн дансны тухай хуулийн 3.1.4-т хамаарах улсын төсвийн хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр нийт 2,631.2 сая төгрөгийн ажил гүйцэтгэсэн 43 хуулийн этгээд огт мэдээлэл байршуулаагүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,261.9 сая төгрөгийн 9 ажлыг 8 хуулийн этгээд, ОНХС-гийн хөрөнгөөр 1,237.4 сая төгрөгийн 37 ажлыг 31 хуулийн этгээд, сургуулиудын үдийн цай хөтөлбөрт 4 хуулийн этгээд, 1 иргэн нийт 131.9 сая төгрөгийн ажил гүйцэтгүүлсэн боловч Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлээгүй байна.

Тухайлбал: улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд 512.0 сая төгрөгийн 7 ажлыг 6 хуулийн этгээд, 2018 онд 749.9 сая төгрөгийн 2 ажлыг 2 хуулийн этгээд, 5 сургуулийн үдийн цай хөтөлбөрийн гүйцэтгэгчээр 4 хуулийн этгээд, 1 иргэн гүйцэтгэсэн байна.

Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр 14 хуулийн этгээдээр 893.6 сая төгрөгийн 18 ажил гүйцэтгүүлсэн бөгөөд 3 хуулийн этгээд цэс нээлгэсэн боловч мэдээлэл огт байршуулаагүй бол 11 хуулийн этгээд огт цэс нээлгээгүй, мөн сумдын ОНХС-гийн хөрөнгөөр 17 хуулийн этгээдээр 343.8 сая төгрөгийн 20 ажил гүйцэтгүүлсэн боловч тус компаниуд нь цэс нээлгээгүй байна.

Эдгээр нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтыг зөрчсөн байна.

Иймд орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цэстэй байх, гүйцэтгэж байгаа ажилтай холбоотой мэдээллийг бүрэн байршуулдаг байх тухай шаардлагыг техникийн нөхцөлд дурьдаж, дээрх шаардлагыг хангасан байгууллагуудыг сонгон шалгаруулах тухай зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

2.3. Шилэн дансны тухай хуулийн 3.1.5-д хамаарах 4 хувийн цэцэрлэгээс 1 цэцэрлэг нь хуулийн 6 дугаар зүйлийн 6.9-д заасан мэдээллийг бүрэн байршуулаагүй байна.

Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газраас “Хонгорхон”, “Бүжинхэн”, “Буян”, “Олуулаа” гэсэн 4 хувийн цэцэрлэгт санхүүжилт хуваарилдаг бөгөөд Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цэс нээлгэсэн байна.

Эдгээр цэцэрлэгүүд нь 2017, 2018 онд нийт 189.6 сая төгрөгийн санхүүжилтийг хүлээн авсан бөгөөд 185.8 сая төгрөгийн санхүүжилтийг мэдээлсэн байна.

Нийт 16 мэдээлэл байршуулахаас 15 мэдээлэл байршуулсан ба үүний 4 буюу 25.0% нь хугацаа хоцорсон төлөвтэй, 1 мэдээллийг огт байршуулаагүй бөгөөд Олуулаа цэцэрлэг 2018 оны 9 сард авсан 3.8 сая төгрөгийн санхүүжилтийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлээгүй байна.

Шилэн дансны тухай хуульд заасан холбогдох байгууллага, албан тушаалтан хяналтыг хэрэгжүүлж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлсэн эсэх

Бүлэг 3

Шилэн дансны тухай хуульд заасан хөндлөнгийн хяналтыг сумдын ИТХ, ИНХ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.1. Шивээговь, Баянтал сумын ИТХ болон багийн ИНХ нь хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аймаг, сумдын ИТХ болон багийн ИНХ-аас хуулийн дагуу хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлж ажиллахаар хуулинд заасан бөгөөд аудитын явцад аймгийн ИТХ, Сүмбэр сумын ИТХ, Шивээговь сумын ИТХ-аас хяналт хэрэгжүүлж ажилласан талаарх холбогдох шийдвэр, ажлын тайлан, мэдээллийг гаргаж ирүүлсэн боловч Шивээговь сумын ИТХ-ын тогтоолын хэрэгжилт хангалтгүй байсан ба Баянтал сумаас мэдээлэл ирүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал.....хэрэгжүүлнэ” гэснийг мөрдөж ажиллаагүй байна.

Иймд уг хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах чиг үүрэг бүхий байгууллагууд хуулиар олгогдсон чиг үүргээ хэрэгжүүлж, гарсан алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т “Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд “төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ” гэж хуульчилсны дагуу аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь аймгийн ТЕЗ-ийн хүрээний төсвийн байгууллагууд, ОНӨҮГ-уудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2018 онд сар бүр хяналт тавьж, тайланг аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ, Санхүү, төрийн сангийн хэлтэст тус тус тайлагнаж, мэдээллийн самбар гарган дүгнэсэн байна.

Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2018 оны 3 дугаар улирлын байдлаарх аймаг, сумдын 47 байгууллага, давхардсан тоогоор 79 байгууллагад хяналт тавьж ажиллан сар бүрийн мэдээллийг дутуу байршуулсан, улирлын тайланг илгээгээгүй, хагас, бүтэн жилээр оруулах мэдээллийг байршуулаагүй зөрчил илэрснийг 55 байгууллагад албан бичиг, 14 байгууллагад хугацаатай албан шаардлага хүргүүлж ажилласнаар өмнөх оны мөн үеэс 14.8%-иар буурсан үзүүлэлттэй гарсан байна.

3.2. Хуулийн 3.1.4-т заасан байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд төсвийн ерөнхийлөн захирагчид хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3.1.4-т хамаарах улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цэс нээлгээгүй бөгөөд захиалагч байгууллагын зүгээс шаардлага тавьж ажиллаагүй байна.

3.3. Шилэн дансны нэгдсэн цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан мэдээлэл иргэд, олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар хүрэхгүй байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан мэдээллүүд нь иргэд олон нийтэд ойлгомжтой, үнэн зөв, хүртээмжтэй мэдээлэл хүрэхгүй байна. Тухайлбал: зарим мэдээллийн хүснэгт дутуу бөглөсөн, хэтрэлт хэмнэлтийн шалтгааныг бүрэн бичээгүй, оруулсан мэдээллийн фонт танигдахгүй байх зэрэг зөрчил илэрч байна.

Мөн интернэт орчинд ажилладаггүй буюу Шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг ашиглах боломжгүй хүмүүст мэдээллийн самбараар дамжуулан мэдээлэл хүргэх зорилготой боловч олон нийтийн анхаарал татсан хөрөнгө оруулалтын шинжтэй ажил, худалдан авах ажиллагааны мэдээлэл, хөрөнгө зарцуулсан талаарх шийдвэрийг мэдээлэхгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн иргэд, олон нийтэд мэдээлэл үнэн зөв, иж бүрэн, ач холбогдолтой байх зарчмыг хангахгүй байгаа бөгөөд мэдээлэл бүх шатанд хүртээмжтэй байдлаар хүрэхгүй байна.

3.4. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг Шивээговь, Баянтал сумдын ИТХ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өмнөх аудитаар аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанд хуулийн хэрэгжилтийг хангуулах 5 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан бол бүх шатны ИТХ-д хүргүүлсэн зөвлөмжийг сумдын ИТХ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аудитаар нийт 3,791.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж, зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлагыг 27 байгууллагын холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Шивээговь, Баянтал сум нь Байгаль хамгаалах сан, Мал хамгаалах сангийн дансдыг хаагаагүйгээс ажил гүйлгээ гардаггүй сангийн цэс байсаар байна.
2. Нийт 74 цэс нээлгэснээс 64.0% буюу 47 байгууллага мэдээллээ бүрэн оруулж, 36.0% хувь буюу 27 байгууллага мэдээллийг алдаатай буюу дутуу байршуулсан байна.
3. Шилэн дансны мэдээллийг дутуу байршуулсан, байршуулсан нийт мэдээллийн 13.0% нь хугацаа хоцорсон төлөвтэй байна.
4. Мэдээлэл дутуу байршуулсан байгууллагын тоо өмнөх оноос 32.0%-иар, хугацаа хоцорсон мэдээллийн тоо 20%-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна.
5. Мэдээллийн самбарт хуульд заасан мэдээллүүдийг бүрэн мэдээлэхгүй байна.
6. Шилэн дансны тухай хуулийн 3.1.4-т хамаарах улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цэс нээлгээгүй, цэс нээлгэсэн боловч мэдээллийг огт байршуулаагүй байна.
7. Байгууллагуудын шилэн данс хариуцсан ажилтнууд шилэн дансанд холбогдох мэдээллийг оруулахдаа нэгдсэн цахим хуудас дахь маягтыг бүрэн бөглөх шаардлагатай боловч байгууллагын үйл ажиллагаатай холбогдолгүй гэсэн хайхрамжгүй үйлдлээс мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулаагүйтэй холбоотой байна.
8. Шилэн дансны нэгдсэн цахим хуудас болон мэдээллийн самбар дахь мэдээллүүд нь иргэд, олон нийтэд ойлгомжтой, хүтээмжтэй байдлаар хүрэхгүй байна.
9. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байна.
10. Хөндлөнгийн хяналтыг сумдын ИТХ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараахь зөвлөмжийг өгч байна.

Бүх шатны ИТХ-ын дарга нарт:

1. Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу хяналт тавих эрхээ бүрэн хэрэгжүүлж ажиллах

Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга Н.Алтанцэцэг танаа:

1. Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, үйл ажиллагааны явцад дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллах, дотоод хяналтын тайланг холбогдох албан тушаалтанд тайлагнах,
2. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсан дахь сумдын Байгаль хамгаалах сан болон Мал хамгаалах сангийн ажил гүйлгээ хийгдэхгүй байгаа цэсийг хаалгах
3. Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8 болон Мэдээллийн ил тод байдал мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу мэдээллийн самбарт хуульд заасан мэдээллүүдийг бүрэн мэдээлж байх талаар харьяа байгууллагуудтай хамтран ажиллах
4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх тал дээр анхаарч ажиллах

Аймгийн ОНӨГ-ын болон сумдын ЗДТГ-ын дарга нарт:

1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цэстэй байх, гүйцэтгэж байгаа ажилтай холбоотой мэдээллийг бүрэн байршуулдаг байх тухай шаардлагыг техникийн нөхцөлд дурьдаж, дээрх шаардлагыг хангасан байгууллагуудыг сонгон шалгаруулах

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас ирүүлсэн санал:

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН
АЛБА
42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг,
Нутгийн удирдлагын ордон 305 тоот,
E-mail: sankhuu_audit_ga@yahoo.com
2018.11.30 № 193
тавай 2018.11.28-ны № 247 -г

Г ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ Г

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийгдсэн Нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцан дараахь саналыг хүргүүлж байна.

Хавсралт 1 хуудас

ДАРГА  ТАЛАНЦЭЦЭГ

УСХА0001 4014924
420101092

4230000009

"ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ"-д
хийгдсэн нийцлийн аудитын тайланд санал хүргүүлэх тухай


2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр.

1. Шилэн дансны тухай хуулийн 3.1.4-т хамаарах улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цэс нээлгээгүй байна. Энэ талаар аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Тайлбар: Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т "Улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуй нэгж байгууллагууд хуулийн үйлчлэх хүрээнд хамаарч байгаа хэдий ч тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д зааснаар шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурал, иргэдийн Нийтийн хурал, Төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ гэж заасан байдаг. Иймээс манай байгууллага нь тус заалтыг хянах ямар ч боломжгүй. Учир нь Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т энэ хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд"-д заасан төсвийн байгууллага албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу манай байгууллага хийнэ.

Жич: Иймээс зөвлөмжид тусгагдсан дээрх заалттай холбоотой 2 заалтыг хасуулах саналтай байна. /2, 5 дугаар заалт/

Санал бичсэн:



/Н.Алтанцэцэг/

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ХИЙСЭН ТАЙЛБАР

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас ирүүлсэн албан бичигтэй танилцаад Шилэн дансны тухай хуулийн 3.1.4-т хамаарах улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудад хяналт тавьж ажиллах болон гүйцэтгэгч сонгон шалгаруулалттай холбоотой зөвлөмжийг засварласан болно.



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2018 оны 11 сарын 30 өдөр

Дугаар А/24

Чайр

Нийцлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2016 оны А/146 дугаар тушаалаар батлагдсан "Нийцлийн аудитын түр журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.2, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2017 оны А/188 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.2, 2.4-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Ерөнхий аудиторт 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт"-д хийгдсэн аудитын тайлан, илэрсэн зөрчлийн жагсаалт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

2. "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт"-д хийгдсэн аудитын тайланг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газар болон аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанд тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитын тайланд дурьдагдсан зөрчлүүдийг арилган, өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, түүний үр дүнг 2019 оны 03 дугаар сарын 25-ны дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга Н.Алтанцэцэгт зөвлөсүгэй.

4. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аудитор Б.Анхтуяад даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.САРАНТУЯА

D:\DOTOOD AJIL\TUSHAAL.doc

80071